

ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ТАЙЛАН

2020.06.19

Чингис хот

НЭГ. ДОТООД АЖИЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус хэлтсийн хамт олон төрийн бүртгэлийн үйлчилгээг хүн амд шударга, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх, бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах зорилгыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд ирсэн албан бичиг 983 үүнээс шийдвэрлэсэн хариутай бичиг 214, явуулсан албан бичиг 568 байв.

Тайлангийн хугацаанд 40 өргөдөл, хүсэлт ирсний 29 нь иргэдээс, 11 нь хэлтсийн албан хаагчдаас ирсэн байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэж, хариу өгч ажилласан. Хэлтсийн албан хаагчдын санал хүсэлтийн дэвтрээр нийт 22 тэмдэглэл бичигдснээс 21 талархал, 1 хүсэлт байв.

УБЕГ-ын даргын 27 тушаал, иргэний бүртгэлийн чиглэлээр 8, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 12, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 1 чиглэл, бусад /хэлтэстэй холбоотой/ 6 чиглэл, зөвлөмж тус тус ирснийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулан судлуулж бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын 21 тушаал гарсан. Үүнд: Албан хаагчидтай холбоотой 10, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 11 нийтээр дагаж мөрдөх шинж чанартай тушаал байв.

Албан хаагчдын ХАСХОМ-ийг хугацаанд нь гаргаж баталгаажуулан, УБЕГ-ын Захиргаа, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн. 2020 онд шинээр томилогдсон 2 албан хаагчийн ХАСХОМ-ыг 30 хоногийн дотор гаргуулж баталгаажуулсан. Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдын “Төрийн албан хаагчийн анкет” А, Б хэсэг, хувь хүний намтарыг шинэчилж бичин УБЕГ-т хүргүүлсэн.

Хэлтсийн албан хаагчдын ажлын ачаалал, давхардлыг арилгах, ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэх зорилгоор ажил үүргийг тодорхой, үр дүнтэй, оновчтой хуваарилах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахын тулд үндсэн ажлаас гадуур ажил үүргийн хуваарь гарган ажилладаг бөгөөд хуваарийг 2020 оны байдлаар шинэчлэн баталж эзэнжүүлсэн. Жил бүр албан хаагчдад ажил үүргийг сольж хуваарилдаг. Ажил үүргийн хуваарийн дагуу холбогдох ажлын төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гарган ажилласан.

Хэлтсийн албан хаагчдын мэдээллийн цагийн календарчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж 14 хоног тутам хэлтсийн албан хаагчид өөрийн хариуцсан ажил үүргийн чиглэлээр хийсэн ажлыг удирдлагад товч танилцуулан ажиллаж хэвшсэн.

Сумдын болон хэлтсийн улсын бүртгэгч нар сар бүр хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сар бүрийн тасаг, нэгжийн төлөвлөгөөний биелэлт дунджаар 90-100 хувьтай биелэгдсэн.

2020 оны хагас жилийн хэлтсийн болон улсын бүртгэгч нарын гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж 2020 оны 01 дүгээр улирлын улсын бүртгэгч нарын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлж дүгнэсэн.

Хэлтсийн 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн биелэлтийг гарган Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газарт албан бичгээр хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн тухай багц хууль, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар 90 үйлчлүүлэгчээс судалгаа авч Захиргаа хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтад иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 3 санал, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-1санал, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 3 тус тус тусгуулахаар холбогдох газарт явуулсан. Иргэний улсын бүртгэлийн системийн шинэчлэлийг турших явцад гарсан 7 саналыг нэгтгэн ИУБГ-т цахим хаягаар илтгэх хуудсын хамт хүргүүлсэн.

Тус аймаг дахь Үндэсний аюулгүй байдал хариуцсан орон тооны ажлын хэсэгт мэдээ, мэдээллээр хангах дүрмийн дагуу улсын бүртгэлийн байгууллагаас 2 дугаар улирлын байдлаар Үндэсний аюулгүй байдлын аймаг дахь орон тооны ажлын хэсэгт иргэний улсын бүртгэлтэй холбоотой /Иргэний шилжилт хөдөлгөөн, төрөлт өсөлт, бууралт/ тоон мэдээллийг 3 хавсралтаар гаргаж хүргүүлсэн. 2 дугаар улирлын тоон мэдээ гарах хугацаа холбогдох журмын дагуу болоогүй.Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хамаарах 3 төрлийн тоон мэдээг нэгтгэн Аймаг дахь Үндэсний аюулгүй байдал хариуцсан орон тооны ажлын хэсэгт хүргүүлсэн. АЗДТГазарт ирсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсгийн хуралд оролцож чиг үүргийн дагуу мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан.улирал бүр өгөх танилцуулгыг 4 удаа гаргаж хүргүүлсэн.

Сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийх ажил үүргийн хуваарийг гаргаж батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Дэлгэрхаан сумын 5 дугаар баг /Баянхаан/-ийг шинээр байгуулсантай холбоотой гарсан ИТХ-ын тогтоол, багийн хилийн зураглал, хүн амын судалгааг ИУБГ-т хүргүүлж 409 иргэний хаягийг мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр тусгуулсан.

ХОЁР.УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний улсын бүртгэл: Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн нийт 1194 бүртгэлийг 18 сум, 5 тосгоноос хүлээн авч, холбогдох дүрэм журмын дагуу нягтлан шалгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шивж баталгаажуулсан. Үүнд:


1. Төрөлт-758
2. гэрлэлт 164
3. гэр бүл цуцлалт 19
4. хүүхэд үрчлэлт 17

5. овог нэр өөрчлөлт 30
6. эцэг тогтоолт 31
7. нас баралт 175

Сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон авч нэгтгэн УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газарт хугацаанд нь дотоод сүлжээний 192.168.154.100, j.narantuya@burtgel.gov.mn хаягаар 5 удаа хүргүүлэн ажилласан.

Шилжилт хөдөлгөөний бүртгэл: Аймаг, нийслэл хооронд шилжин ирсэн 450, сум, баг доторх шилжилт хөдөлгөөний 679 иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэж баталгаажуулсан. УБЕГ-ын даргын 2020.01.20-ны өдрийн А/126 тоот тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл түр зогсоож, тушаалын хэрэгжилтийг ханган холбогдох арга хэмжээ авч ажилласан. Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоосон тухай илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлж, 2019.12.10-ны өдрөөс 2020.01.31-нийг дуустал хугацаанд бүртгэсэн ИУБ-22 маягтыг нотлох баримттай нэг бүрчлэн тулгалт хийж хянасан. Түр оршин суух иргэдийн тоон мэдээг Багийн дарга нараас авч нэгтгэн ИУБГ-т 1 дүгээр улирлын байдлаар хүргүүлээд байна.


Шилжин ирсэн иргэдийн бүртгэлийн тоог сүүлийн 3 жилийн мөн үетэй харьцуулбал:




Үндэсний энгийн гадаад паспорт: Үндэсний энгийн гадаад паспортын захиалга 159 иргэнээс хүлээн авч гадаад паспорт олгох үйлчилгээ үзүүлсэн.

Лавлагаа олголт: Холбогдох хууль хяналтын байгууллагад улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа, мэдээллээр хангах ажлын хүрээнд албан байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу иргэний бүртгэлтэй холбоотой 247 лавлагаа, иргэнд иргэний бүртгэлтэй холбоотой 5941 лавлагаа тус тус олгосон.

Иргэний улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа олголтыг сүүлийн 3 жилийн мөн үетэй харьцуулбал:



Иргэний цахим үнэмлэх: Тайлангийн хугацаанд 1534 иргэнд иргэний цахим үнэмлэх олгосон. Үүнд: шинэ- 490, дахин-280, сунгалт-764 тус тус байна. Иргэний үнэмлэх бүртгэлийн үйл ажиллагааны явцад 87 иргэний мэдээллийн зөрчил, дутагдлыг журмын дагуу арилгаж /ургийн овог, оршин суугаа хаяг санд тусгагдаагүй, эцэг/эх/-ийн нэр, нэрийг буруу бүртгэсэн гэх мэт.../ санд мэдээллийг үнэн зөв болгож иргэний үнэмлэхийг олгосон байна.



❖ Иргэний бүртгэлийн архив:

Архивийн сангийн баяжилтыг цаг тухай бүрт нь хийж нийт 1325 хувийн хэрэгт баяжилт хийсэн ба архивын фондоос 172 хувийн хэрэг татан авч шалгасан байна. Шилжин ирсэн 450 иргэний хувийн хэргийг нэмж санд оруулан, өөр аймаг хотод шилжин явсан 97 иргэний хувийн хэргийг холбогдох газарт нь хүргүүлж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Иргэний баримтын архивын баримтыг excel файлаар шивж бүртгэх ажил 99 хувьтай явагдаж байна. БНШК-д хадгалах хугацаа дууссан ИУБ-22 маягт 6022, ИУБ-21 маягт 5430 нийт 11452 маягт устгуулах саналыг хүргүүлээд байна.

❖ Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа

Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ авах нийт 2770 мэдүүлэг хүлээн авч 2743 бүртгэл хийсэн. Үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан газрын бүртгэл 286, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл-100, шинэ орон сууцны бүртгэл 12, төрөөс үнэгүй хувьчилсан орон сууц-2, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсгэх-13, өмчлөх эрх шилжих гэрээ-357, бүртгэлд өөрчлөлт оруулах-97, барьцааны гэрээ-814, барьцааны гэрээ дуусгавар -735, бусад бүртгэл 4, иргэн хуулийн этгээдэд 323 лавлагаа хуулбар олгож, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээний хураамж 40638888, ҮХЭХ борлуулсны орлогын албан татвар 41999200, тэмдэгтийн хураамж 481500 нийт 83119588 төгрөгийн орлогыг улс болон орон нутгийн төсөв төвлөрүүлээд байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл газрын дугаар олгох систем болон дундын мэдээллийн санд оруулж цахимаар 525 мэдүүлэг хүлээн авч үүнээс 40 мэдүүлгийг буцах үндэслэлийг бичиж буцаан 485 нотлох баримтыг шалгаж эзэмших “э” дугаар олгож хувийн хэрэг үүсгэн архивын нэгж болгосон.

Тайлангийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн газар, Шүүх, Прокурор зэрэг эрх бүхий байгууллагад 87 албан бичгээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй эсэх 105 лавлагаа олгож, 31 эд хөрөнгөнд эд хөрөнгө сэргээх болон түдгэлзүүлэх тогтоолыг үндэслэн эрх түдгэлзүүлэх болон сэргээх тусгай тэмдэглэл хийсэн. Мөн Хэнтий аймаг дахь ШШГГ, Нийслэлийн ШШГГазраас ирүүлсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай тогтоолуудыг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн ү-1817000876, ү-1804001228, Ү-1819000336, ү-1804000134, ү-1819000846, г-1817000567, ү-1818000020, г-1810000916, ү-1804001434, г-1817000515, ү-1817002004, ү-1817000069, ү-1817000013, г-181700207, ү-1817002634, г-1817001088, г-1817001926, ү-1817000446, ү-, дугаартай хувийн хэргүүдэд бүртгэлийг хийж холбогдох арга хэмжээг авч хариуг хүргүүлсэн.

❖ Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаа

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хуулийн хүрээнд үнэн зөв хүргэж тайлант хугацаанд: Хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт **570** бүртгэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Шинээр байгуулсан хуулийн этгээд – Нийт: **101**
 - Хоршоо -1
 - ХХК-39
 - ТББ-7
 - ХХК,ХМБ-1

- ЗГБХНөхөрлөл-52
- ҮЭБ-1
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт – 116
 - Татан буугдсан-1
- Оноосон нэрийн баталгаажуулалт – 171
- Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны хуудас – 144
- Хураан авсан тамга-38 тус тус бүртгэгдсэн байна.

Архивт хуулийн этгээдийн нийт 2233 хувийн хэрэг эх нотлох баримт хадгалагдаж байна. Тайлангийн хугацаанд нийт 217 хувийн хэрэгт баяжилт хийгдэж, шинээр 93 хувийн хэрэг шинээр үүсгэн цахимжуулан архивчид зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн.


Хууль хяналтын байууллагын шийдвэрээр 8 хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөх оруулах эрхэд хориг тавьж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 1 хуулийн этгээдийн хориг цуцалж нотлох баримтыг бүрэн цахимжуулсан. Салбар төлөөлөгчийн газрын нийт 9 бүртгэлийг бүртгэж хувийн хэргийг холбогдох газарт хүргүүлсэн. 2-р улирлын байдлаар шинээр байгуулагдсан 101, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан 116 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБ-12 маягтын дагуу хүлээн авч бүртгэн мэдээллийн санд үнэн зөв тусгасан байна.

❖ Улсын бүртгэлийн архивын үйл ажиллагаа

Иргэний баримтын архив Архивийн сангийн баяжилтыг цаг тухай бүрт нь хийж нийт 1325 хувийн хэрэгт баяжилт хийсэн ба архивын фондоос 172 хувийн хэрэг татан авч шалгасан байна. Шилжин ирсэн 450 иргэний хувийн хэргийг нэмж санд оруулан, өөр аймаг хотод шилжин явсан 97 иргэний хувийн хэргийг холбогдох газарт нь хүргүүлж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Иргэний баримтын архивын баримтыг excel файлаар шивж бүртгэх ажил 99 хувьтай явагдаж байна. БНШК-д хадгалах хугацаа дууссан ИУБ-22 маягт 6022, ИУБ-21 маягт 5430 нийт 11452 маягт устгуулах саналыг хүргүүлээд байна.

Иргэний улсын бүртгэлийн лавлагаа олголт: Холбогдох хууль хяналтын байгууллагад улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа, мэдээллээр хангах ажлын хүрээнд албан байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу иргэний бүртгэлтэй холбоотой 247 лавлагаа, иргэнд иргэний бүртгэлтэй холбоотой 5941 лавлагаа тус тус олгосон.

Иргэний улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа олголтыг сүүлийн 3 жилийн мөн үетэй харьцуулбал:



Мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг хангаж эрх солигдсон бүртгэгчийн онлайн системд хандах, хаах эрхийг тухай бүр УБЕГ-т албан бичгээр хүргүүлж мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хяналт тавьж байна. Тайлангийн хугацаанд 9 албан бичгээр давхардсан тоогоор 25 албан хаагчийн мэдээллийн санд хандах эрхийг нээлгэсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архив: Архивын ерөөний агаарын чийгшил, дулааныг хэмжих хэрэгслийн тусламжтайгаар тогтмол хэмжиж тэмдэглэл хөтлөж байна. Архивт үл хөдлөх эд хөрөнгийн 7855 газрын 14063, эзэмших 1561, ашиглах 3 нийт 23482 хувийн хэрэг эх нотлох баримт хадгалагдаж байна. Тайлангийн хугацаанд нийт 2330 хувийн хэрэг баяжилт хийгдэж, анхны бүртгэлийн 892 хувийн хэрэг шинээр хүлээж авсан. Архивын баталгаажсан бүртгэлийн тоон үзүүлэлтийн мэдээг мэдээллийн самбар болон цахим сүлжээнд тогтмол байршуулж байна.

ЭХЭБ-ийн чиглэлээр олгосон лавлагаа: Тайлангийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн газар, Шүүх, Прокурор зэрэг эрх бүхий байгууллагад 87 албан бичгээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй эсэх 105 лавлагаа олгож, 31 эд хөрөнгөнд эд хөрөнгө сэргээх болон түдгэлзүүлэх тогтоолыг үндэслэн эрх түдгэлзүүлэх болон сэргээх тусгай тэмдэглэл хийсэн. Мөн Хэнтий аймаг дахь ШШГГ, Нийслэлийн ШШГГазраас ирүүлсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай тогтоолуудыг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн ү-1817000876, ү-1804001228, Ү-1819000336, ү-1804000134, ү-1819000846, г-1817000567, ү-1818000020, г-1810000916, ү-1804001434, г-1817000515, ү-1817002004, ү-1817000069, ү-1817000013, г-181700207, ү-1817002634, г-1817001088, г-1817001926, ү-1817000446, ү-, дугаартай хувийн хэргүүдэд бүртгэлийг хийж холбогдох арга хэмжээг авч хариуг хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архив: Тайлант хугацаанд Төрийн байгууллагад 28 лавлагаа, хуулбар 40, Иргэн хуулийн этгээдэд үнэт цаасаар 97 лавлагаа, цахим мэдээллийн сангаас хуулбар 33 тус тус хүсэлтийн дагуу олгосон байна. Архивын 7 төрлийн журналыг хөтлөн явуулж шинэ болон нэмэлт

өөрчлөлтийн жагсаалтыг хадгаламжийн нэгж үүсгэн ажиллаж байна. Шашны байгууллагын судалгаа, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй шашны байгууллагын судалгаа, хуулийн этгээдийн сүүлийн 8 жилийн өсөлт бууралтыг гарган хугацаанд нь хүргүүлсэн. Шашны байгууллагын судалгаанд нэмэлт өөрчлөлт орсон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг тусган хүргүүлсэн. Аймгийн ЗДТГазарт ирсэн Үндэсний аюулгүй байдлын ажлын хэсэгт 2020 оны 5 сарын байдлаар мэдээ мэдээллийг шинэчилэн хүргүүлсэн.

ГУРАВ. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЛААР

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар иргэний шинэчилсэн бүртгэлийг алдаатай бүртгэсэн 11, иргэний гэр бүлийн 14 бүртгэлийн зөрчлийг илрүүлж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан мэдээллийн санд залруулга хийж зөрчлийг арилгасан.
- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр лавлагаа олгох явцад иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд төрсний бүртгэл алдаатай орсон 57 иргэний мэдээллийг холбогдох газарт хүргүүлж 37 иргэний зөрчлийг арилгаад байна.
- Регистрийн дугаарын зөрчилтэй 7 иргэний хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу хяналтын улсын байцаагч дүгнэлт гарган регистрийн дугаарыг өөрчилсөн. 2017 оноос хойш регистрийн дугаар өөрчилсөн 53 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгагдсан эсэхийг шалгахад регистрийн дугаар өөрчилсөн бүртгэл бүрэн тусгагдаж баталгаажсан байна.
- Иргэний бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэл ороогүй 2 иргэний бүртгэлийг архивын баримтыг үндэслэн нөхөн бүртгэж санд тусгасан.
- Сар бүр улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтын тайланд хяналт тавьж гаргасан алдааг тухай бүр арилгуулан ажиллаж байна.
- 2019.01.01-ний өдрөөс өмнө буюу 2018 оны 11 дүгээр сард төрсөн 1 хүүхдэд онлайн сангаас улсын ахлах бүртгэгч регистрийн дугаар олгож бүртгэл хөтөлсөн.
- МУИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд нэг хаяганд 10-аас дээш сонгогч бүртгэлтэй байгаа 1000 иргэний жагсаалт ИУБГ-аас ирүүлснийг сум тус бүрээр нь жагсаалтыг хүргүүлж тулгалтыг хийлгэн нэгтгэлийг гаргаж хүргүүлсэн. Шилжин явсны бүртгэл хийлгээд очих газраа бүртгүүлээгүй мэдээллийн санд хаягийн бүртгэлгүй 148 иргэнтэй холбогдож шилжилт хөдөлгөөн түр зогсохоос өмнө 13 иргэний хүсэлтийг авч бүртгэж хаягжуулсан.
- Мөн эцэг/эх/-ийн нэр, нэр, төрсөн огноо ижил 114 иргэний мэдээллийг санд тулган, регистрийн дугаар өөрчлөгдсөн боловч энэ тухай санд тусгагдаагүй 2 регистрийн дугаараар санд бүртгэлтэй байгаа 28 иргэний нэг регистрийн дугаарыг хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилгасан.
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 140, иргэний улсын бүртгэлийн 854, хуулийн этгээдийн бүртгэлийн 45, архивын 126 баримтад шалгалт хийж, шалгалтын явцад гарсан 16 зөрчлийг тухай бүр бүртгэгч нараар арилгуулсан.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн дагуу эд хөрөнгийн бүртгэл дахин цахимжуулах тухай 9, бүртгэл хүчингүй болгох тухай 4, зөрчил арилгах тухай 28, регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай 9, хуулийн этгээдийн бүртгэлийн 5, бүртгэлд засвар оруулах 1 хяналтын улсын байцаагчийн дүгнэлт тус тус гаргаж Хяналтын газраар баталгаажуулан нийт 55 дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлж ажилласан.
- 2020 оны 2-р улиралын байдлаар Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24.1, 15.24.2, 15.24.4-т заасны дагуу 167 иргэн, 2 хуулийн этгээдэд хялбаршуулсан журмаар тус бүр 500 төгөргөөр торгох арга авч прокурорын газараар хянуулж ажилласан. Орон нутгийн төсвийн дансанд торгууль 4.680,000 төгрөгийг төвлөрүүлсэн.
- Мөрөн сумын төсөвт 5 байгууллага болон аймгийн төвийн 5 сүмээр очиж ажилласан Мөрөн сумын Соёлын төв, ЕБ сургуульд сануулах арга хэмжээ авсан. Сүм хийдээс Очих газар Баптист сүмд ЗТХуулийн 15. 23 дагуу 500,000 мянган төгрөгөөр торгох арга хэмжээ авсан мөн Галшар сумын ЕБС-ийг торгох арга хэмжээ авсан.
- Бүртгэгч нарын бүртгэлд хяналт шалгалт хийж зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор 16, 25, 45 насны сунгалт хийх иргэдэд хэрхэн хугацаандаа бүртгэлээ хийлгэх талаар сануулж байхыг сумдын бүртгэгч нарт чиглэл өгсөн.
- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар иргэний шинэчилсэн бүртгэлийг алдаатай бүртгэсэн 11, иргэний гэр бүлийн 14 бүртгэлийн зөрчлийг илрүүлж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан мэдээллийн санд залруулга хийж зөрчлийг арилгасан.
- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр лавлагаа олгох явцад иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд төрсний бүртгэл алдаатай орсон 57 иргэний мэдээллийг холбогдох газарт хүргүүлж 37 иргэний зөрчлийг арилгаад байна.
- Регистрийн дугаарын зөрчилтэй 7 иргэний хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу хяналтын улсын байцаагч дүгнэлт гарган регистрийн дугаарыг өөрчилсөн. 2017 оноос хойш регистрийн дугаар өөрчилсөн 53 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгагдсан эсэхийг шалгахад регистрийн дугаар өөрчилсөн бүртгэл бүрэн тусгагдаж баталгаажсан байна.
- Иргэний бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэл ороогүй 2 иргэний бүртгэлийг архивын баримтыг үндэслэн нөхөн бүртгэж санд тусгасан.
- Сар бүр улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтын тайланд хяналт тавьж гаргасан алдааг тухай бүр арилгуулан ажиллаж байна.
- 2019.01.01-ний өдрөөс өмнө буюу 2018 оны 11 дүгээр сард төрсөн 1 хүүхдэд онлайн сангаас улсын ахлах бүртгэгч регистрийн дугаар олгож бүртгэл хөтөлсөн.
- МУИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд нэг хаяганд 10-аас дээш сонгогч бүртгэлтэй байгаа 1000 иргэний жагсаалт ИУБГ-аас ирүүлснийг сум тус бүрээр нь жагсаалтыг хүргүүлж тулгалтыг хийлгэн нэгтгэлийг гаргаж хүргүүлсэн. Шилжин явсны бүртгэл хийлгээд очих газраа бүртгүүлээгүй

мэдээллийн санд хаягийн бүртгэлгүй 148 иргэнтэй холбогдож шилжилт хөдөлгөөн түр зогсохоос өмнө 13 иргэний хүсэлтийг авч бүртгэж хаягжуулсан.

- Мөн эцэг/эх/-ийн нэр, нэр, төрсөн огноо ижил 114 иргэний мэдээллийг санд тулган, регистрийн дугаар өөрчлөгдсөн боловч энэ тухай санд тусгагдаагүй 2 регистрийн дугаараар санд бүртгэлтэй байгаа 28 иргэний нэг регистрийн дугаарыг хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилгасан. УБЕГазраас ирүүлсэн 2020 оны 02 сарын 28-ны 7/1960 тоот чиглэлийн хүрээнд Улсын байцаагчийн шаардлагын дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд анх удаа бүртгэхдээ мэдээллийн санд газрын нэгж талбарын дугаар тусгаагүй 69 бүртгэлийг жагсаалтыг гаргаж нэгж талбарыг тусган улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан мэдээллийн санд өөрчлөлт оруулах арга хэмжээг авч илтгэх хуудсыг хугацаанд нь ЭХЭУБГазарт хүргүүлж ажилласан.
- 2019 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 7/9562 дугаартай чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-д бүртгэлийн төрөл, эд хөрөнгийн төрлийг буруу сонгосны улмаас газар өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа баталгаажуулах төлөвтэй 7 бүртгэл, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан газрын өмчлөх төлөвтэй 2 бүртгэл төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг бүртгэх төлөвтэй 3 бүртгэл, нийт 12 бүртгэлийг цаасан суурьт эх нотлох баримт болон цахим системд тулгалтыг хийж нягтлан шалгаж, эрхийн улсын бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт илтгэх хуудсыг ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТАЛААР

- МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан. 2020.02.01-ний өдрөөс иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг аймгийн хэмжээнд түр зогсоон, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүрэн тусгаж баталгаажуулсан.
- Сонгуулийн хэсэг, нутаг дэвсгэр төвийг зарласан сумдын ИТХТ-ийн тогтоолыг нэгтгэн УБЕГ-т хүргүүлж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд санал авах байрны мэдээлэл, харъяалах хаягийн мэдээллийг шивж баталгаажуулсан.
- Тус аймгийн хэмжээнд 89 сонгуулийн хэсэг байгуулагдсан. Иргэний бүртгэлийн онлайн программд 18 дугаар тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад хэсгийн дугаар оноох, хэсэг оноогдсон сонгогчдын хэсгийн мэдээллийг нягтлан шалгаж, хэсэг оноогдоогүй байсан сонгогчид хэсэг оноох ажлыг 100 хувь зохион байгуулан ажиллав. Тус аймгийн хэмжээнд УИХ-ын сонгуулийн 18 дугаар тойргийн 1-89 дүгээр хэсгийн 50552 сонгогчид хэсгийн дугаарыг оноосон. Энэ тухай хийсэн ажлын тайланг бичиж ИБГ-т хүргүүлсэн.

- Мөн 18 сумын ИТХТ-ийн сонгуулийн хэсэг, нутаг дэвсгэр төвийг зарласан талаарх тогтоолуудыг election.gasr.mn-д мэдээллийг шивж, тогтоолын эх хувийг файл хэлбэрээр оруулсан.
- УБЕГ-аас ирүүлсэн сонгогчийн тоон мэдээллийг албан бичгээр аймгийн сонгуулийн хороонд хугацаанд нь хүргүүлсэн.
- Сонгуулийн санал авах байрны дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж 89 сонгуулийн хэсэгт ажиллах 96, нөөц 3 албан хаагчийн жагсаалтыг төрийн албан хаагчийн анкет, иргэний үнэмлэхийн хуулбарын хамт аймгийн Тагнуулын хэлтэст зөвшөөрөл авахаар тус хэлтсийн 2020.04.27-ны өдрийн 1/402 албан бичгээр хүргүүлж, 2020.05.12-ны өдрийн 48/63 тоот албан бичгээр зөвшөөрсөн хариуг авсан.
- Burtgel.gov.mn хаягаар сонгогчийн мэдээлэл зөрүүтэй гэж мэдэгдсэн 3 сонгогчтой утсаар холбогдон холбогдох тайлбарыг тодруулж, энэ талаар ИУБГ-т тухай бүр илтгэх хуудсыг хүргүүлж ажилласан.
- Итгэмжлэгдсэн ажилтнуудын эрх зүйн болон программын сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж оролцогчдыг 100 хувь бүрэн хамруулсан.
- Сонгогч шилжих хүсэлт, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гаргасан хүсэлтийн дагуу иргэний улсын бүртгэлийн сангаас сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах 1184 лавлагаа /шилжин ирсэн 618, шилжин явсан 536, түр хасав тэмдэглэгээ сэргээх 9, нас барсан 14, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 7/ хэвлэж, холбогдох сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулж эцсийн байдлаар сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэсэн.
- Сонгогчийн ирц бүртгэлийн программ бүхий тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг УБЕГ-аас хуваарийн дагуу 2020.06.04-ний өдөр татан авч, аюулгүй байдлыг ханган аймгийн Тагнуулын хэлтэст хүлээлгэн өгсөн. Программын сургалт болох газарт 2020.06.11-ний өдөр тоног төхөөрөмжүүдийг цагдаагийн хамгаалалтанд хүргэж, байлган сургалт дууссаны дараа аймгийн Иргэний танхимд авчирч байрлуулан лацдаж цагдаагийн хамгаалалт авсан. Хэсгийн хороодод сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмж, сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх ажлыг аймгийн Сонгуулийн хороотой хамтран тохиролцож 2020.06.16-ны өдөр 4 чиглэлийн маршрутаар цагдаа, тагнуулын байгууллагын хяналт дор хэлтсийн 4 албан хаагч цуг явж тоног төхөөрөмж, СНЖ-г актаар хүлээлцэв.

ТАВ.ТӨСӨВ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн бусад холбогдох хууль журам зааврын дагуу гаргаж 2020.01.23 өдөр Хэнтий аймаг дахь аудитын газраас **“ЗӨРЧИЛГҮЙ”** санал дүгнэлтээр баталгаажууллаа. УБЕГазарт нэгтгүүлэн, Сангийн яамны “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан” онлайн програмд шивж жилийн эцсийн санхүүгийн тайлангаа цаг хугацаанд нь хүлээлгэж өгсөн.

Татварын хэлтэст 2019 оны бүтэн жилийн 4 төрлийн тайлангаа цаг хугацаанд нь цахим хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Монгол улсын сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын дагуу төсвийн шинэчилсэн ангилалыг мөрдлөг болгон ажиллаж байна. Төсвийн тухай хуулийн 16.5.7 заалтын дагуу 2020 онд 10 төрлийн мэдээг цаг хугацаанд нь гаргаж УБЕГазарт хүргүүлээд байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”- д Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг тухай бүр, сар бүр, улирал тутам гаргаж УБЕГазрын хяналт үнэлгээ шинжилгээ дотоод аудитын газарт илгээж ажиллаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 оны 05 сарын байдлаар төсөв гүйцэтгэл цэсэнд 17 мэдээлэл, хөрөнгө оруулалт тендер худалдан авалт цэсэнд 17 мэдээлэл, бусад цэсэнд 26 мэдээлэл нийт 37 мэдээллийг хуулийн хугацаанд цахим болон мэдээллийн самбарт байршуулсан.

2020 оны 03 дугаар сарын байдлаар батлагдсан төсвийг 12 779 138 мянган төгрөгөөр хэмнэн ажиллаж шалтгаан тайлбарыг шилэн дансны нэгдсэн системд бүрэн мэдээлсэн. “Байгууллагын админ эрх”-ээр 1-р улирлын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны илгээж цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.

❖ Төсвийн ил тод нээлттэй байдлын талаар

Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоол “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах” журмын хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг мэдээллийн самбарт сар бүрийн төсөв, гүйцэтгэлийг өссөн дүнгээр гарган иргэд, болон олон нийтэд нээлттэй хүргүүлж байна.

Төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор төсвийн байгууллагын төсвийн мэдээллээ Сангийн яамны шилэн дансны нэгдсэн цахим сайт болон мэдээллийн самбараар мэдээллэх ажил тогтмолжсон.

2020 оны 5-р сарын байдлаар 219 470 400 төгрөгийн төсөв батлагдан ирснийг Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай 206 691 262 төгрөгийн гүйцэтгэлтэйгээр зарцуулан нийт 12 779 138 төгрөгийг хэмнэж ажиллаад байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 26 538 000 төгрөг дээд шатны төсвийн захирагчаас шилжин ирсэн. Итгэмжлэгдсэн ажилтаны томилолтын зардалд 11 628 000 гүйцэтгэл гарсан.

2020 оны 05 дугаар сарын байдлаар 4 албан хаагчдын томилогоо хийгдээг цалингийн сан 4 663 314 төгрөгөөр хэмнэгдээд байна.

Мөн энэ хугацаанд шуудан холбооны зардлыг 1 65 377 төгрөгөөр хэмнэн ажилласан. /албан бичгийн хувь хүнээр дамжуулан явуулж хэмнэж байгаа боловч хувь хүний нууц болон үнэт цаас алдагдах эрсдэлтэй байна/. Хэмнэсэн зардлыг тоног төхөөрөмжийн ашиглах хугацаа дуусаж чанарын шаардлага хангахгүй хор их хэмжээгээр ордог мөн эд хөрөнгийн бүртгэл хийхэд бичгийн цаас их хэмжээгээр зарцуулагддаг. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлсантай холбогдуулан цаг үеийн байдалд нийцүүлэн ариутгалын материал худалдан авах


зардалд 803 000 төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гарсан.

❖ Үнэт цаас зарцуулалтын талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 471,472,473 дугаар тушаалаар батлагдсан “Гэрчилгээ, маягт түгээх, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Үнэт цаасыг бүртгэгч нарт хатуу дугаарын дагуу журнал хөтлөн олгож үнэт цаасны нэгдсэн программд бүртгэгч тус бүрээр хувиарлаж хэвшсэн.

Үнэт цаас татан авах тайлагнах журмын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 3 962 390 төгрөгийн 29200 ширхэг гэрчилгээ маягт татан авсан, улсын бүртгэгч нарт 3 464 295 төгрөгийн 21090 ширхэг гэрчилгээ маягт зарцуулсан байна. Сумдын болон хэлтсийн улсын бүртгэгч нараас сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон үнэт цаасны тайланг цаг хугацаанд нь авч сум бүрээр нэгтгэн УБЕгазарт хүргүүлж хэвшсэн. 2020 оны 05 сарын байдлаар хүчингүй үнэт цаас бүртгэгчийн алдаа 114 техникийн алдаа 60, нийт 174 ширхэг хүчингүй үнэт цаас гаргасан байна. Хүчингүй үнэт цаасыг өмнөх үетэй харьцуулсан судалгааг гарган ажиллаа. 2020 оны эхний улирлын байдлаар хүчингүй үнэт цаас гаргалт ихэссэн шалтгаан нь сумдын бүртгэгч нар орон нутгатаа лавлагаа гаргаж эхлсэн мөн тоног төхөөрөмжийн чанар муудсантай холбоотой техникийн алдаа их гарсан.



❖ Орлого төвлөрүүлтийн талаар


Засгийн газрын 2010 оны 237 тогтоолоор тогтоосон үйлчилгээний хөлсний хураамж нь 5 сарын байдлаар 58 871 222.88 төгрөгийн орлого төвлөрсөнийг бүртгэл тус бүрээр гаргахад доорх үзүүлэлтийн хувьтай байна.



Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг 7 жилээр харьцуулсан байдал



Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг хувиар харьцуулсан байдал



Хагас жилийн байдлаар Орон нутгийн төсөвт Эд хөрөнгө анхны удаа бүртгүүлсэний тэмдэгтийн хураамж 481 500, Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамж 6 602 000, Иргэний үнэмлэхний тэмдэгтийн хураамж 5 062 200, Иргэн шилжилт хөдөлгөөн хийсний тэмдэгтийн хураамж 1 223 000 төгрөгийн орлого, Эд хөрөнгө худалдан борлуулсаны орлого 41 999 200 төгрөг, торгуулийн

орлого 9 130 000 нийт 6 497 900 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Улс болон орон нутгийн төсөвт нийт 123 369 122.88 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.

ЗУРГАА:ХЭЛТСИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Терроризмоос урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд Хэлтсийн байрны хяналтын 3 ширхэг камер, тэжээлийн блок гэмтсэнийг шинээр сольж гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Аймгийн тагнуулын хэлтэст терроризмоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авах хүсэлтийг хүргүүлээд байна. УБЕГ-аас зохион байгуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр онлайн сургалтанд нийт албан хаагчид хамрагдсан.
- Мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг хангаж эрх солигдсон бүртгэгчийн онлайн системд хандах, хаах эрхийг тухай бүр УБЕГ-т албан бичгээр хүргүүлж мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хяналт тавьж байна. Тайлангийн хугацаанд эрх нээх, хаах тухай 7 албан бичгээр 30 албан хаагчийн мэдээллийн санд хандах эрхийг нээлгэсэн
- Хууль зүйн сайдын 2014 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Журмын хэрэгжилтийг өдөр тутам ханган ажиллаж хэвшсэн. Мэдээллийн сантай танилцах, ашиглах, солилцох, өөрчлөлт оруулах эрх бүхий албан хаагчдаар “нууцын баталгаа”-г 2019 онд шинэчилж гаргуулж авсан. Мэдээллийн технологи хариуцсан ажилтан 1 удаа холбогдох сургалтанд хамрагдсан.

ДОЛОО: АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ ЧАДАВХЖУУЛАХ ТАЛААР

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 онд зохион байгуулах 28 заалт бүхий сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж баталсан.

УБЕГазар болон Улсын Бүртгэлийн Хэлтсээс зохион байгуулсан 13 удаагийн цахим сургалтдад давхардсан тоогоор 250 албан хаагчид хамрагдсан.

- 2020.01.17-ны өдөр УБЕГазраас зохион байгуулсан “Орон нутаг дахь Улсын Бүртгэлийн байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргагүй “ сэдэвт цахим сургалтад хамрагдсан.
- 2020.02.10-14-ны өдөр БНСУ-ын бүртгэлийн системтэй танилцах сургалтад орон нутгийн бүртгэлийн байгууллагыг төлөөлж тус хэлтсийн дарга Б.Төрхүү хамрагдсан./Зураг-1/
- 2020.03.23-ны өдөр ЭХЭУБГ-ын дарга Б.Ариунболд “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хууль журмын дагуу хөтлөх” зөвлөмж чиглэл анхаарах асуудлуудын талаар онлайн сургалтад хамрагдсан.
- 2020.03.23-ны өдөр АЗДТГазрын ХШҮДАГ-ын дарга Н.Баярцолмон “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах,

ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам “-ын талаар сургалтанд хамрагдсан.

- 2020.03.24-ны өдөр Улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалтыг Улсын Бүртгэлийн Хэлтсээс онлайнаар зохион байгуулж, сумдын бүртгэгч нарт “МУИХ-ын сонгуулийн тухай хууль”, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн талаар тус тус мэдээлэл хийж, чиглэл өгсөн./Зураг-2,3/
- 2020.04.08-ны өдөр УБЕГазраас Сонгуулийн ажлын хэсгийн онлайн сургалтад хэлтсийн дарга хяналтын улсын байцаагч, иргэний ахлах бүртгэгч нар хамрагдсан./Зураг-4,5/
- 2020.04.15,16-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн онлайн сургалтад хэлтсийн дарга Б.Төрхүү хамрагдсан. /Зураг-6,7/
- 2020.04.17-ны өдөр УБЕГ-с зохион байгуулсан бичиг хэргийн ажилтнуудад зохион байгуулсан онлайн сургалтад бичиг эрхлэгч хамрагдсан.
- 2020.04.22-ны өдөр УБЕГазар Иргэний улсын бүртгэлийн системийн нэвтрүүлэх төлөвлөгөөг танилцуулах, туршилтыг хэрхэн гүйцэтгэх тухай танилцуулах зөвлөмж, ИУБ хөтлөлт анхаарах асуудал сэдэвт сургалтад Ш.Мөнхзул хамрагдсан.
- 2020.04.30-ны өдөр УБЕГ-ын Хуулийн этгээдийн газраас зохион байгуулсан Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл хөтлөх, анхаарах асуудал сэдэвт онлайн сургалтад ХЭУБүртгэгч О.Энх-Ариун хамрагдсан.
- 2020.05.06-08-ны өдрүүдэд УБЕГ-ын Бүртгэлийн Хяналт Шалгалтын Газраас зохион байгуулсан онлайн сургалтад хяналтын улсын байцаагч О.Ганбаатар хамрагдсан.
- 2020.05.19-ны өдөр МУ-ын УИХ-ын сонгуулийн хэсгийн хорооны дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны эрх зүйн сургалтад УБЕГ-аас ирүүлсэн хөтөлбөрийн дагуу холбогдох хичээлийг хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар нийт итгэмжлэгдсэн ажилтангуудад хийсэн. /Зураг-8,9/
- 2020.05.20-ны өдөр Аймгийн сонгуулийн хорооноос зохион байгуулсан сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарын сургалтад МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих” талаар мэдээлэл хийсэн.
- 2020.05.26-ны өдөр Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2020 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, албан хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим сургалтын хөтөлбөр ийн дагуу “Хуурамч баримт бичиг, түүнийг таних заавар”, “Тамга тэмдэг ашиглах, хуурамчаар баримт үйлдэхээс урьдчилан сэргийлэх”, “Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хийж байгаа гэмт халдлагын төрөл, хийгдэх болсон шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх” тухай онлайн сургалтанд хамрагдсан.
- 2020.05.27-ны өдөр Засгийн газрын “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай “01 дүгээр албан даалгаврыг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүүхдийн эрхийн

хамгаалалын асуудлаар мэдээлэл өгөх зорилготой “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай онлайн сургалтад хамрагдсан.

- 2020.06.11-06.12-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны сонгогчийн ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг УБЕГ-ын сургалтын баг удирдан зохион байгуулж чиглэл, арга зүйгээр ханган ажилласан./Зураг-9/
- Аймгийн сонгуулийн хорооны зөвлөлдөх уулзалтанд 2 удаа оролцож улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийн дагуу сонгуулийн бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийсэн./Зураг-12,13/
- Шинээр томилогдсон улсын бүртгэгч нарт удирдлага арга зүйн зөвлөгөө өгч чадавхижуулж ажилласан. /Зураг-16/
- МУ-ын УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудсанд 2020.04.01-ний өдрөөс байршуулсан тул иргэдэд өөрийн мэдээлэлтэй танилцах боломж нээлттэй байгаа талаар сурталчлан ажиллахыг улсын бүртгэгч нарт албан бичгээр чиглэл хүргүүлж, аймгийн төвийн замын урсдаг самбаруудаар энэ тухай тогтмол мэдээлж ажилласан.

Тус хэлтэс нь өөрийн khentii.burtgel.gov.mn цахим хуудас, “Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” facebook хаяг тогтмол ажиллуулж зохион байгуулсан ажлын талаар 27 видео бичлэг , пэйж хуудсанд 141 зурагт мэдээ, мэдээлэл байршуулан улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар мэдээллийг нээлттэй олон нийтэд хүргэж дагагчийн тоо 2519-д хүрсэн. Улсын ахлах бүртгэгч Ц.Соёл-Эрдэнэ “Хэнтий мэдээ агентлаг” мэдэх эрх-39 шууд нэвтрүүлэг оролцон улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр хураамжийг төлөх Киоск машин түүний давуу талаархи мэдээлэл хийсэн. Ковид 19 өвчний тархалт өдөр өдрөөр нэмэгдэж байгаа энэ цаг үед хариуцлагатай байж маскаа зүүхийг уриалан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд challenge-д нэгдсэн.

ЕС: АЛБАН ХААГЧДЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

- УБЕГ-ын даргын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-өөс өгсөн үүрэг, чиглэлийг хэлтсийн болон сумдын нийт албан хаагчдад танилцуулан чиглэлийг бичгээр хүргүүлсэн.
- Бүртгэлийн үйл ажиллагаандаа зөрчил гаргасан 1 албан хаагчид УБЕГ-ын даргын 2019 оны Б/97 тоот тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. Албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, холбогдох хууль, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгч, арга зүйгээр хангаж ажилласан.
- Байгууллагын ёс зүйн зөвлөлийн судалгааг АЗДТГ-т 2020.05.01-ний өдөр гаргаж хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан талаар өргөдөл, гомдол ирээгүй. 1 улсын бүртгэгчийг албан үүргээ хангалтгүй

биелүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнд хариуцлагагүй хандсан тул даргын зөвлөлийн гишүүд протоколоор сануулах арга хэмжээ авсан.

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх УБЕГ-ын 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тус хэлтэст хамаарал бүхий заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар нийт албан хаагчдад танилцуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг үүрэг болгосон. Төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж хүргүүлсэн.

НАЙМ: АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ ТААТАЙ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

- Уламжлалт баяр “Цагаан сар”-аар хэлтсийн 7 ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг хүргүүлсэн.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр /2020.03.08/-өөр хэлтсийн бүсгүйчүүдэд хүндэтгэл үзүүлсэн.
- АЗДТГ-ийн хөрөнгөөр 10 сая төгрөгийн өртөг бүхий 2 компьютер, 5 ширхэг 3 үйлдэлт принтер, 2 ширхэг принтерийг хэлтэст хүлээлгэн өгсөн бөгөөд тус тоног төхөөрөмжүүдийг албан хаагчдад хуваарилан хэвийн ажиллагаанд оруулсан.
- Хэлтсийн хамт олны хуримтлалын санд одоогийн байдлаар 4 140 000 төгрөг хуримтлуулж албан хаагчдын нийгмийн асуудал, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зарцуулж байна.
- МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг дор жил бүр зохион байгуулагддаг “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр, мөн тус аймгийн ИТХТ-ийн тогтоолоор сар бүрийн сүүлийн долоо хоногийн “Бямба” гаригийг “Гэр бүлийн хөгжлийн өдөр” болгосонтой холбогдуулан 2020.05.25-ны өдөр “Хайрын төгөл”-д албан хаагчид, гэр бүлээрээ мод тарих ажиллагаанд оролцож мод тарьсан.
- Хэлтсийн албан хаагчдын 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг үнэлж 32 албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.
- Бүртгэлийн хууль, дүрэм, журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан бүртгэлийн үйлчилгээнд ашиглаж байгаа мэдээллийн самбар, гарын авлагын мэдээллийг шинэчлэн хэвлүүлж бүх сумдын бүртгэгч бүрт хүргүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор зайнаас мэдрэгч халууны шил, резинэн бээлий, гар ариутгагч, халдваргүйжүүлэх спирт, амны хаалт, ариутгалын бодисыг худалдан авч хэлтсийн албан хаагчдын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн хэлтсийн байранд халдваргүйжүүлэлтийг Зооноз өвчин судлалын төвөөр 2 удаа хийлгэсэн. Иргэд тус байгууллагаар үйлчлүүлэхдээ гараа ариутгах, үйлчилгээний зааланд үйлчлүүлэгч хоорондын зайг барих тэмдэглэгээг хийж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, зөвлөмж бүхий зурагт хуудсыг ил харагдах газарт байршуулсан. Мөн хэлтсийн албан хаагчдад 185 200 төгрөгийн өртөг бүхий витаминжуулалтыг хийсэн. “Амны хаалтаа зүүцгээе”

challenge-д нэгдэж видео хэлбэрээр уриалга гарган цахим хуудаст байршуулсан. /Зураг-17/

- УБЕГазрын Албан тушаалд томилох-12, чөлөөлөх-5, цалингийн шатлал нэмэгдүүлэх-4, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох-4 саналыг УБЕГазарт хүргүүлсэн.
- 2020 оны 05 дугаар сарын 12-ны 3/4636 тоот албан бичгийн дагуу Их Монгол Улс байгуулагдсаны 814 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 99 жил, Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн баярыг тохиолдуулан Засгийн газрын шагналд нэр дэвшүүлэх шаардлага хангасан 3 албан хаагчдын материалыг Төрийн захиргаа, хүний нөөцийн хэлтэсд хугацаанд нь хүргүүлсэн.
- Төрийн байгууллагуудын Хэрлэн голын эрэг дагуу их цэвэрлэгээ хийх ажилд хэлтсийн албан хаагчид идэвхи санаачлагатай оролцов.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд хэлтсийн албан хаагчдын 71 хүүхдэд гарын бэлэг гардуулсан.
- Хэлтсийн шинэ байрны Шинэ барилгын төслийн хураангуй мэдээлэл болон зураг төслийг УБЕГ болон ЗДТГ-ын Хөрөнгө Оруулалт болон хөгжлийн хэлтэст хүргүүлсэн.
- Мөн 2021 оны төсвийн төсөлд шинэ барилгын 1.266.374.115 төгрөгийн төсвийг суулгуулах саналыг хүргүүлсэн
- “Үйлчилгээний соёл, стандартыг хангах зорилгоор үйлчилгээний зааланд мэдээллийн самбар 1 ширхэг хийсэн, цонхны хөшгийг шинэчилсэн. /Зураг-18,19/
- “Ахмадын баяр”-ыг угтаж тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан 7 ахмад настанд хүндэтгэл үзүүлж, нийт 350 000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.
- “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.10 дахь заалтын дагуу 2019 оны шилдэг ажилтанаар шалгарсан 2 албан хаагчдад 200 000 төгрөгийн шагнал урамшуулал олгосон.

АРАВ: БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Өмчлөх эрхийн бүртгэлийг орон нутагт хүргэх зорилтын хүрээнд сумын бүртгэгчийн ирүүлсэн бүртгэлийн тоо 368 байна. Үүнээс үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл-25, төрөөс үнэгүй хувьчилсан газар-127, гэрээний эрхийн бүртгэл-202, лавлагаа-14, тус тус бүртгэл хийгдэж өмчлөх эрхийн 146 гэрчилгээ олгогдсон байна. Хамгийн олон бүртгэл ирүүлсэн сум Өмнөдэлгэр/60/, Бор-Өндөр/200/ сумд байна.

- Үйлчилгээний танхимд “хөтөч ажилтан” ажиллуулж байгаа нь бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай болгоход ач холбогдлоо өгсөөр байна. Тайлангийн хугацаанд хөтөч ажилтнаас 3150 иргэн үйлчилгээ авсны 98 хувь нь эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээ авах иргэд байсан.
- Хэлтсийн вэб сайтыг энэ онд тогтмол ажиллуулж мэдээллийн баяжилтыг сайжруулсан. Хагас жилийн байдлаар нийт улсын бүртгэлийн үйл

ажиллагаатай холбоотой 169 мэдээ, мэдээллийг байршуулан олон нийтэд мэдээлсэн. Сумын улсын бүртгэгч бүр facebook хаяг нээж улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж байгаа нь үр дүнгээ өгч байна.

АРАВ НЭГ: ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР

Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр болон утас, саналын хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факсаар хүлээн авч шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 40 санал, хүсэлт, талархал ирсний 11 хүсэлт, 29 өргөдөл, санал хүсэлтийн дэвтрээр 125 талархал байв.

Төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор төсвийн байгууллагын төсвийн мэдээллээ Сангийн яамны шилэн дансны нэгдсэн цахим сайт болон мэдээллийн самбараар мэдээллэх ажил хэвшсэн. Тайлангийн төсөв санхүүгийн үйл ажиллагаа хэсэгт дэлгэрэнгүй бичсэн болно.

Хэлтсийн сар бүрийн улсын бүртгэлийн статистик тоон үзүүлэлтийн эмхэтгэлийн хураангуйг байгууллагын цахим хуудсаар болон хэвлэмэл байдлаар тогтмол нээлттэй хүргэж байна.

АРВАН ХОЁР: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР

- Тахилгат тосгоны улсын бүртгэгч Б.Нарангаравыг жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд Э.Өнөрбаярыг, Мөн Мөрөн сумын улсын бүртгэгчийн сул орон тоо нөхөгдөөгүй байгаа тул УБЕГ-ын даргын 2020 оны 05 дугаар сарын 18-ны Б/263 тоот тушаалаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ж.Дашням албан үүргийг хавсран гүйцэтгэж байна. Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ө.Лхагва-очир өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөн тул дээрх орон тоонд УБЕГ-ын даргын 2020 оны Б/181 тоот тушаалаар Б.Төгсжаргалыг томилон ажиллуулж байна.
- Биндэр сумын улсын бүртгэгч Ц.Ононцэцгийн хүүхэд асрах чөлөө дуусгавар болсон тул УБЕГазрын даргын 2020 оны 04 сарын 10-ны өдрийн Б/185 тоот тушаалаар А.Гэрэлмааг үүрэгт ажлаас чөлөөлж УБЕГазрын даргын 2020 оны 04 сарын 10-ны Б/180 тоот тушаалаар Биндэр сумын улсын бүртгэгчийн үүрэгт ажилд томилсон.
- Мөн сул орон тоотой байгаа Баянмөнх, Галшар сумын бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор зэргэлдээ сумын улсын бүртгэгчийг албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлж хуваарь гарган тухайн суманд очиж ажиллаж байна.
- Тайлангийн хугацаанд 3 өдөр /5 дугаар сарын 15,16,17 аймгийн хэмжээнд 05-20 цагт эрчим хүчний хязгаарлалт хийгдсэн бөгөөд энэ өдрүүдэд цахилгаан үүсгүүр ажиллуулж хэлтсийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулсан.

АРВАН ГУРАВ: СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 онд зохион байгуулах 28 заалт бүхий сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж баталсан. Улсын бүртгэлийн үйл ажиллагаа тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журмыг иргэдэд сурталчилах, мөн МУ-ын УИХ-ын сонгуульд ажиллах хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтнуудтай уулзан сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогч шилжих талаар 1196 иргэнд мэдээлэл өгч ажилласан

- 2020.02.10-ны өдөр Хасбанкны харилцааны менежер, теллер нийт 14 албан хаагч нарт “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн танилцуулга, “Барьцааны гэрээний тухай ойлголт, анхаарах асуудлаар” сургалт мэдээлэл хийсэн.
- 2020.05.28-29-ны өдрүүдэд МУ-ын УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг сумдын хэсгийн хороонд хүргэх ажлыг 3 чиглэлд маршрут гарган зохион байгуулсан. Хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, иргэний улсын ахлах бүртгэгч нар өөрсдийн явсан чиглэлийн сумдын хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтнуудтай уулзан сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогч шилжих талаар мэдээлэл өгч ажилласан. /Зураг-10,11/
- 2020.01.20.22-ны өдрүүдэд Улсын бүртгэгч Х.Сэргэлэн Биндэр суманд, 2020.05.14.15-ны өдрүүдэд Улсын бүртгэгч Ч.Ууганбаяр Бор-Өндөр суманд, 2020.05.20.21-ний өдрүүдэд Улсын бүртгэгч Б.Сийлэгмаа Галшар суманд тус тус эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж ажилласан. /зураг-14,15,16/

САНАЛ

Хэлтсийн улсын бүртгэгч нарын ашиглаж байгаа компьютер техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан эвдрэл гэмтэл ихтэй байгаа тул бүртгэлийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгаа тул тоног төхөөрөмжийн шинэчлэлийг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хэлтсийн барилгын зураг төсвийг тусгуулж өгөхийг уламжилж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТӨРХҮҮ

